



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 11 дугаар
сарын 06 өдөр

Дугаар А-007

Улаанбаатар
хот

Сан байгуулах тухай

1. Нийслэлийн ядуурал, ажилгүйдлийг бууруулах амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой ядуу, нэн ядуу амьдралтай айл өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг төмс, хүнсний ногоо, газар тариалан, түр болон улирлын шинж чанартай хөдөлмөр эрхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Газрын буян" санг Нийслэлийн нийгмийн халамжийн албаны дэргэд байгуулсугай.

2. "Газрын буян" сангийн дүрмийг хэвсралтаар баталсугай

3. Сангийн захирлаар Нийгмийн халамжийн албаны дарга Авирмэд овогтой Эрдэнэбаатарыг томилсугай.

4. Сангийн хөрөнгийн өх үүсвэрийг бүрдүүлэхэд 1997 онд хэрэгжүүлсэн "Газрын буян" төслөөр бий болсон хөрөнгийг ашиглан, үр дүнтэй, зориулалтын дагуу зарцуулахыг сангийн захирал А. Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.

5. Сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлын чиглэл удирдамжаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (н.Хадхүү)-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.Наранцацралт Ж.НАРАНЦАЦРАЛТ



Нийслэлийн Засаг даргын 1997 оны
А/207 Дотоо захирамжийн хавсралт.

**НИЙГМИЙН ЭМЗЭГ ХӨСӨГТ ТУСЛАХ
"ГАЗРЫН БУЯН" САНГИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийглэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилт нь нийслэлийн ядуу, нэн ядуу амьдралтай хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Газрын буян" сангийн (цаашид сан гэх) хамрах хүрээг тогтоож санг бүрдүүлэх, зарцуулах эрх зүйн үндэс, сангийн үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлоход оршино.

1.2. Санг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.

1.3. Сан нь нийслэл хотын ядуу, нэн ядуу амьдралтай хүн амын хөдөлмөрийн чадвартай иргэдээр төмс, хүнсний ногоо тариалах, ой цөвөрлөх, түлш бэлтгэх зэрэг улирлын болон түр шинж чанартай нийтийг хамарсан ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, богино хугацааны хөнгөлөлттэй жижиг зээл олгоход зориулагдана.

1.4. Сангийн үйл ажиллагаа нь "нийгмийн халамжийн тухай" Монгол улсын багц хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийн хүрээнд явагдана.

1.5. Сангийн хөрөнгийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан энэ дүрмийн дагуу Нийслэлийн нийгмийн халамжийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Нийслэлийн нийгмийн халамжийн албаны дарга захиран зарцуулж, гүйцэтгэлийн тайланг жил бүр тайлагнана.

1.6. Сан нь тусгай данстай байх бөгөөд тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Сангийн эх үүсвэр, зарцуулалт

2.1. Сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ.

а/ Сангийн хөрөнгийг ашиглуулсны төлөө банк болон бусад байгууллагаас авах хүү, ногдол ашиг.

б/ Дотоод, гадаадын аж ахуйн нэгж, айгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж.

в/ Санхүүгийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнгийн орлого

г/ Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

2.2. Сангийн мөнгөн хөрөнгө нь доорх зүйлд зарцуулагдана.

а/ Сангийн зорилгод нийцсэн төслийг хэрэгжүүлэх

б/ Төрийн бус байгууллагаас ядуу, нэн ядуу амьдралтай иргэдээр хөдөлмөр эрхлүүлэх ажлыг дэмжих.

Гурав. Сангийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

3.1. Санг Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан 5–7 хүний бүрэлдэхүүнтэй Нийгмийн халамжийн зөвлөл удирдана.

3.2. Сангийн захирал нь нийслэлийн Нийгмийн халамжийн албаны дарга байна. Сан нь зохицуулагч, ажлын албатай байж болно.

3.3. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг сангийн зохицуулагч эрхлэн гүйцэтгэнэ.

3.4. Сангийн өмч хөрөнгийн ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй хяналтын зөвлөл ажиглана. Хяналтын зөвлөлийг нийслэлийн Нийгмийн халамжийн зөвлөлийн хүрлээр байгуулж ажиллуулна.

3.5. Сангийн захирал дор дурдсан эрх үүрэгтэй.

а/ Сангийн хяналтын зөвлөлийн гишүүдийг батлуулахаар нийслэлийн Нийгмийн халамжийн зөвлөлийн хуралд өргөн барих.

б/ Сангийн хөрөнгийг нийслэлийн нийгмийн халамжийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

в/ Санг төлөөлөн хуулийн бусад этгээдтэй хэлцэл хийх

г/ Сангийн гүйцэтгэлийн зарцуулалтын дүнг Нийслэлийн Нийгмийн халамжийн зөвлөлд тайлагнах.

д/ Илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулах

е/ Санг өөрчлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргэд санал оруулах.

ё/ Санд хөрөнгө хуримтлуулах ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Санд бодитой хувь нэмэр оруулсан иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн энэрэнгүй үйлсийг хэвпэл мэдээллээр олон түмэнд сурталчилж алдаршуулах, урамшуулах.